



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ДАШЗЭГВИЙН АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201

Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,

Цахим шуудан: info@cabinet.gov.mn,

Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.12.20 № ЗГ-1/161
танай _____-ны № _____-т

**Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай**

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2014.12.16 № ХЭГ/2570
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 70 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,


Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024. 11.22 № 1/1952
танай _____-ны № 01/1313 -т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



О.АЛТАНГЭРЭЛ

151604675
А5 маяг 2024



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn


2024.11.29 № 01/9862

танай 2024.11.21 -ны № 01/1314 -т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Таны ирүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаад Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761003110

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлд:


“15.ХЭЛЭЛЦСЭН нь: Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**



Л.ЭНХ-АМГАЛАН 4070603

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**



О.АЛТАНГЭРЭЛ

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5-д “Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх” гэж заасан.

УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ мөрдөгдөж эхлэхээс өмнө батлагдсан тул ажлын байрны төлбөрийг 50 хувь хөнгөлөх зохицуулалтыг хуульд тусгах зайлшгүй шаардлага үүсэж 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Мөн “Шинэ сэргэлтийн бодлого”-ийг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхойлохдоо Боомт, Эрчим хүч, Аж үйлдвэр, Хот, хөдөө, Ногоон хөгжил, Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлого, зорилтын хүрээнд туссан бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд дотоодоос хангах бололцоогүй байгаа ажиллах хүчийг гадаадаас авах боломжийг бүрдүүлсэн байхаар туссан.

Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг зарим салбарт чөлөөлөхтэй холбоотойгоор Засгийн газрын 2023 оны 45 дугаар тэмдэглэлээр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад даалгасан.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглалын судалгаагаар Монгол Улс 2028 он хүртэл хүн амын

Тус яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын “Хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийн барометрийн судалгаа”-гаар 2023 онд аж ахуйн нэгж, байгууллагуудын 26.3 хувь нь ажиллах хүчний хомсдолд орж, шаардлагатай ажилтанг авч ажиллуулж чадаагүй нь судлагдсан. Тус институтээс 2015-2023 оны хугацаанд жил бүр хийж гүйцэтгэсэн “Барометрийн судалгаа”-ны үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн дунд, урт хугацааны чиг хандлагыг таамаглан тооцсон.

Энэхүү таамаглалаар 2025 онд хөдөлмөрийн зах зээлд 1.319,0 мянган хүн ажил хөдөлмөр эрхлэх бөгөөд эдийн засгийн өсөлт 4.9 хувийн өсөлттэй байхын тулд 1.407,0 мянган ажиллагч, 7.2 хувийн өсөлттэй байхын тулд 1.420,0 мянган ажиллагч хэрэгцээтэй. Энэ нь 88.0-101.0 мянган ажиллагч хөдөлмөрийн зах зээлд нэмж нийлүүлэх шаардлагатай болохыг харуулж байгаа юм. Мөн уг үзүүлэлт нь 2028 онд 108.0-135.5 мянга, 2035 он гэхэд 159.0-228.0 мянга байхаар байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Шинэ сэргэлтийн бодлого, улс орны хэмжээнд хэрэгжих томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд 2025 он хүртэл нийт 285.0 мянган ажлын байр бий болох урьдчилсан тооцоолол гарснаас 140.0 гаруй мянга нь бүтээн байгуулалтын үед буюу ойрын хугацаанд бий болохоор байна.

Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн дагуу 2017 онд 11.1 мянга, 2018 онд 10.2 мянга, 2019 онд 10.3 мянган гадаад ажилтан хөдөлмөр эрхэлж байсан бол ковидын нөхцөл байдлаас шалтгаалан энэ тоо 2020-2021 онуудад буурч, 2020 онд 3.8 мянга, 2021 онд 5.3 мянга байсан бол эдийн засаг сэргэж, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа өргөжсөнөөр 2022 онд 10.8 мянга, 2023 онд 19.6 мянган гадаад ажилтан тус тус хөдөлмөр эрхэлсэн байна. Харин 2024 оны эхний 9 сарын байдлаар гадаадын 106 улсын 17831 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 5608 хүнээр буюу 45.8 хувиар нэмэгдсэн байна.

Дээрх нөхцөл байдалтай холбогдуулж хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний хомсдолыг нөхөх зорилгоор гадаадын иргэдийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэхэд уян хатан бодлого баримталж байна.

Тухайлбал гадаадын ажилтан авах бодлогод эдийн засгийн үйл ажиллагааны бүтээмж өндөртэй уул уурхай, олборлолт, мэдээлэл холбоо, санхүү даатгал, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбаруудад гадаад ажилтны тоо, хувь хэмжээг хязгаартай тогтоох, улмаар дотоодын ажиллах хүчнийг эдгээр салбарт түлхүү ажиллуулах нь зүйтэй байна. Харин барилга, эрчим хүч, боловсруулах үйлдвэрлэл зэрэг бүтээн байгуулалтын салбаруудад гадаад ажилтны тоо, хувь хэмжээг хязгаарлалтгүй тогтоож, ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг Засгийн газар тогтоож өгөх шаардлагатай байна.

Мөн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23.4-т “Ажил олгогч хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн санд ажлын байрны зарыг байршуулж, ажилтныг идэвхтэй хайж эхэлснээс хойш ажлын 14 өдрийн дотор дотоодоос ажилтан авч чадаагүй бол гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэх урилга хүсэх эрхтэй.” гэж заасан. Хуульд заасан дээрх хугацаа нь улирлын чанартай бүтээн байгуулалтын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад гадаад ажилтан урих үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд хүндрэл учруулдаг асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

Түүнчлэн гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох хугацаа нь төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсоны дараа шийдвэрлэх нь илүү зохимжтой байна.

Мөн Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 01 дугаар сарын 02-ны өдрөөс мөрдөж эхэлсэн.

Тус хуулийн 8.1 дүгээр зүйлийн 10.1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 8.2 дугаар зүйлийн 9.1 дэх хэсэгт “гадаад ажилтныг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэхээр урих”, 9.2-д “гадаад ажилтан Монгол Улсад хөдөлмөр эрхлэх” энгийн зөвшөөрлийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно гэж заасан.

Мөн хуулийн 7.1.1-д “Энэ хуульд заасан зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явц болон зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид “зөвшөөрлийн нэгдсэн сан” гэх/-тай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна.”, 7.1.5-д “Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална.” гэж тус тус заасан.

Үүний хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 251 дүгээр тогтоолоор “Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх” журмыг батлуулсан.

Тус журмаар зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой явцын мэдээллийг зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тогтмол мэдээлэх, эрх бүртгэж байршуулах, сангаас иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад гарч буй өөрчлөлтийг харгалзан Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулах бөгөөд дараах зохицуулалтыг тусгана:

- Ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг эдийн засаг, бүтээн байгуулалтын бодлого, чиглэлийг харгалзан Засгийн газар тогтоох;

- Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд ашигт малтмал, газрын тосны салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлөхийг Засгийн газар тогтоох;

- Гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох асуудал нь цаг хугацааны хувьд төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой

болсны дараа шийдвэрлэх нь илүү зохимжтой байгаа тул уг тоо, хувь хэмжээг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах;

-Аж ахуйн нэгж, байгууллагууд гадаад улсаас ажилтан авч ажиллуулах урьдчилсан зөвшөөрлийн хүсэлт гаргахад тухайн ажлын байрыг нийтэд ажлын 14 өдөр зарласан байх зохицуулалт нь хүндрэлтэй байгаа тул дээрх хугацааг хүчингүй болгох;

- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 23.10 дахь хэсгийн "Цахим системээр зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх, цахим системийг ашиглах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэснийг хүчингүй болгох хууль зүйн үндэслэлийг бүрдүүлэхээр тус тус тусгасан.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар гадаад ажилтан авч ажиллуулах ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, хөрөнгө оруулагчид төрд төлөх ажлын байрны төлбөрөөс хөнгөлүүлж, чөлөөлөгдөж, бизнес эрхлэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, хөгжлийн төслийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн тухай

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэхгүй.

ТАНИЛЦУУЛГА

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төсөл

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5-д "Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх" гэж заасан. Тус тогтоол Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ мөрдөгдөж эхлэхээс өмнө батлагдсан тул ажлын байрны төлбөрийг 50 хувь хөнгөлөх зохицуулалтыг хуульд тусгах зайлшгүй шаардлага үүсэж, 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг зарим салбарт чөлөөлөхтэй холбоотойгоор Засгийн газрын 2023 оны 45 дугаар тэмдэглэлээр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад даалгасан.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглалын судалгаагаар Монгол Улс 2028 он хүртэл хүн амын насны бүтцээс хамааран ажиллах хүчний хомсдолтой байх үр дүн гарсан.

Тус яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын "Хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийн барометрийн судалгаа"-гаар 2023 онд аж ахуйн нэгж, байгууллагуудын 26.3 хувь нь ажиллах хүчний хомсдолд орж, шаардлагатай ажилтанг авч ажиллуулж чадаагүй нь судлагдсан. Тус институтээс 2015-2023 оны хугацаанд жил бүр хийж гүйцэтгэсэн "Барометрийн судалгаа"-ны үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн дунд, урт хугацааны чиг хандлагыг таамаглан тооцсон.

Энэхүү таамаглалаар 2025 онд хөдөлмөрийн зах зээлд 1.319,0 мянган хүн ажил хөдөлмөр эрхлэх бөгөөд эдийн засгийн өсөлт 4.9 хувийн өсөлттэй байхын тулд 1.407,0 мянган ажиллагч, 7.2 хувийн өсөлттэй байхын тулд 1.420,0 мянган ажиллагч хэрэгцээтэй. Энэ нь 88.0-101.0 мянган ажиллагч хөдөлмөрийн зах зээлд нэмж нийлүүлэх шаардлагатай болохыг харуулж байгаа юм. Мөн уг үзүүлэлт нь 2028 онд 108.0-135.5 мянга, 2035 он гэхэд 159.0-228.0 мянга байхаар байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Шинэ сэргэлтийн бодлого, улс орны хэмжээнд хэрэгжих томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд 2025 он хүртэл нийт 285.0 мянган ажлын байр бий болох урьдчилсан тооцоолол гарснаас 140.0 гаруй мянга нь бүтээн байгуулалтын үед буюу ойрын хугацаанд бий болохоор байна.

Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн дагуу 2017 онд 11.1 мянга, 2018 онд 10.2 мянга, 2019 онд 10.3 мянган гадаад ажилтан хөдөлмөр эрхэлж байсан бол ковидын нөхцөл байдлаас шалтгаалан энэ тоо 2020-2021 онуудад буурч, 2020 онд 3.8 мянга, 2021 онд 5.3 мянга байсан бол эдийн засаг сэргэж, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа өргөжсөнөөр 2022 онд 10.8 мянга, 2023 онд 19.6 мянган гадаад ажилтан тус тус хөдөлмөр эрхэлсэн байна. Харин 2024 оны эхний 9

сарын байдлаар гадаадын 106 улсын 17831 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 5608 хүнээр буюу 45.8 хувиар нэмэгдсэн байна.

Дээрх нөхцөл байдалтай холбогдуулж хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний хомсдолыг нөхөх зорилгоор гадаадын иргэдийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэхэд уян хатан бодлого баримталж байна.

Тухайлбал гадаадын ажилтан авах бодлогод эдийн засгийн үйл ажиллагааны бүтээмж өндөртэй уул уурхай, олборлолт, мэдээлэл холбоо, санхүү даатгал, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбаруудад гадаад ажилтны тоо, хувь хэмжээг хязгаартай тогтоох, улмаар дотоодын ажиллах хүчнийг эдгээр салбарт түлхүү ажиллуулахыг дэмжих нь зүйтэй байна. Харин барилга, эрчим хүч, боловсруулах үйлдвэрлэл зэрэг бүтээн байгуулалтын салбаруудад гадаад ажилтны тоо, хувь хэмжээг хязгаарлалтгүй тогтоож, ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг Засгийн газар тогтоож өгөх шаардлагатай байна.

Мөн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23.4-т "Ажил олгогч хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн санд ажлын байрны зарыг байршуулж, ажилтныг идэвхтэй хайж эхэлснээс хойш ажлын 14 өдрийн дотор дотоодоос ажилтан авч чадаагүй бол гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэх урилга хүсэх эрхтэй." гэж заасан. Хуульд заасан дээрх хугацаа нь улирлын чанартай бүтээн байгуулалтын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад гадаад ажилтан урих үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд хүндрэл учруулдаг асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

Түүнчлэн гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох хугацаа нь төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсны дараа шийдвэрлэх нь илүү зохимжтой байна.

Мөн Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 01 дугаар сарын 02-ны өдрөөс мөрдөж эхэлсэн.

Тус хуулийн 8.1 дүгээр зүйлийн 10.1 дэх хэсэгт "Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрлийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 8.2 дугаар зүйлийн 9.1 дэх хэсэгт "гадаад ажилтныг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэхээр урих", 9.2-д "гадаад ажилтан Монгол Улсад хөдөлмөр эрхлэх" энгийн зөвшөөрлийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно гэж заасан.

Мөн хуулийн 7.1.1-д "Энэ хуульд заасан зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явц болон зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид "зөвшөөрлийн нэгдсэн сан" гэх/-тай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна.", 7.1.5-д "Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална." гэж тус тус заасан.

Энэ хүрээнд Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 251 дүгээр тогтоолоор "Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх" журмыг баталсан.

Тус журмаар зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой явцын мэдээллийг зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тогтмол мэдээлэх, эрх бүртгэж байршуулах, сангаас иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Дээрх зорилт, арга хэмжээ, нөхцөл байдлыг үндэслэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд дараах агуулгатай нэмэлт, өөрчлөлтийг тусгахаар хуулийн төслийг боловсруулсан болно: Үүнд:

1. Ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг эдийн засаг, бүтээн байгуулалтын бодлого, чиглэлийг харгалзан Засгийн газар тогтоох;

2. Гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох асуудал нь цаг хугацааны хувьд төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсоны дараа шийвэрлэх нь илүү зохимжтой байгаа тул уг тоо, хувь хэмжээг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах;

3. Аж ахуйн нэгж, байгууллагууд гадаад улсаас ажилтан авч ажиллуулах урьдчилсан зөвшөөрлийн хүсэлт гаргахад тухайн ажлын байрыг нийтэд ажлын 14 өдөр зарласан байх зохицуулалт нь хүндрэлтэй байгаа тул дээрх хугацааг хүчингүй болгох;

4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-д “нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх.” гэж заасны дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар хуулийн этгээдээс бичгээр шаарддаг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт болон нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолтыг мэдээлэл хариуцагч төрийн байгууллага хооронд цахимаар солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор цаасан лавлагааг “цахим лавлагаа” болгон өөрчлөх;

5. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 23.10 дахь хэсгийн “Цахим системээр зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх, цахим системийг ашиглах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэснийг хүчингүй болгох хууль зүйн үндэслэлийг бүрдүүлэхээр тус тус тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар гадаад ажилтан авч ажиллуулах ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, хөрөнгө оруулагчид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлөх ажлын байрны төлбөрөөс хөнгөлүүлж, чөлөөлөгдөж, зардал хэмнэгдэх, ажиллах хүчний хомсдолоос богино хугацаанд гарах, бизнес эрхлэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, хөгжлийн төслийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Дэлгэрэнгүй танилцуулга

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5-д “Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх” гэж заасан.

УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ мөрдөгдөж эхлэхээс өмнө батлагдсан тул ажлын байрны төлбөрийг 50 хувь хөнгөлөх зохицуулалтыг хуульд тусгах зайлшгүй шаардлага үүсэж 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Мөн “Шинэ сэргэлтийн бодлого”-ийг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхойлохдоо Боомт, Эрчим хүч, Аж үйлдвэр, Хот, хөдөө, Ногоон хөгжил, Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлого, зорилтын хүрээнд туссан бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд дотоодоос хангах бололцоогүй байгаа ажиллах хүчийг гадаадаас авах боломжийг бүрдүүлсэн байхаар туссан.

Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг зарим салбарт чөлөөлөхтэй холбоотойгоор Засгийн газрын 2023 оны 45 дугаар тэмдэглэлээр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад даалгасан.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар гадаад ажилтан авч ажиллуулах ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, хөрөнгө оруулагчид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлөх ажлын байрны төлбөрөөс хөнгөлүүлж, чөлөөлөгдөж, зардал хэмнэгдэх, ажиллах хүчний хомсдолоос богино хугацаанд гарах, бизнес эрхлэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, хөгжлийн төслийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд: Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлд “32.7.Эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт, салбарын бодлого, дотоодын ажиллах хүчний хомсдол зэргийг харгалзан ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газар хөнгөлж, чөлөөлж болно.” гэсэн шинэ заалтыг нэмсэн.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглалын судалгаагаар Монгол Улс 2028 он хүртэл хүн амын насны бүтцээс хамааран ажиллах хүчний хомсдолтой байх үр дүн гарсан.

Тус яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын “Хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийн барометрийн судалгаа”-аар 2023 онд аж ахуйн нэгж, байгууллагуудын 26.3 хувь нь

судлагдсан. Тус институтээс 2015-2023 оны хугацаанд жил бүр хийж гүйцэтгэсэн "Барометрийн судалгаа"-ны үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн дунд, урт хугацааны чиг хандлагыг таамаглан тооцсон.

Энэхүү таамаглалаар 2025 онд хөдөлмөрийн зах зээлд 1.319,0 мянган хүн ажил хөдөлмөр эрхлэх бөгөөд эдийн засгийн өсөлт 4.9 хувийн өсөлттэй байхын тулд 1.407,0 мянган ажиллагч, 7.2 хувийн өсөлттэй байхын тулд 1.420,0 мянган ажиллагч хэрэгцээтэй. Энэ нь 88.0-101.0 мянган ажиллагч хөдөлмөрийн зах зээлд нэмж нийлүүлэх шаардлагатай болохыг харуулж байгаа юм. Мөн уг үзүүлэлт нь 2028 онд 108.0-135.5 мянга, 2035 он гэхэд 159.0-228.0 мянга байхаар байна.

Мөн түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Шинэ сэргэлтийн бодлого, улс орны хэмжээнд хэрэгжих томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд 2025 он хүртэл нийт 285.0 мянган ажлын байр бий болох урьдчилсан тооцоолол гарснаас 140.0 гаруй мянга нь бүтээн байгуулалтын үед буюу ойрын хугацаанд бий болохоор байна.

Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн дагуу 2017 онд 11.1 мянга, 2018 онд 10.2 мянга, 2019 онд 10.3 мянган гадаад ажилтан хөдөлмөр эрхэлж байсан бол ковидын нөхцөл байдлаас шалтгаалан энэ тоо 2020-2021 онуудад буурч, 2020 онд 3.8 мянга, 2021 онд 5.3 мянга байсан бол эдийн засаг сэргэж, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа өргөжсөнөөр 2022 онд 10.8 мянга, 2023 онд 19.6 мянган гадаад ажилтан тус тус хөдөлмөр эрхэлсэн байна. Харин 2024 оны эхний 9 сарын байдлаар гадаадын 106 улсын 17831 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 5608 хүнээр буюу 45.8 хувиар нэмэгдсэн.

Дээрх нөхцөл байдалтай холбогдуулж хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний хомсдолыг нөхөх зорилгоор гадаадын иргэдийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэхэд уян хатан бодлого баримталж байна.

Тухайлбал гадаадын ажилтан авах бодлогод эдийн засгийн үйл ажиллагааны бүтээмж өндөртэй уул уурхай, олборлолт, мэдээлэл холбоо, санхүү даатгал, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбаруудад гадаад ажилтны тоо, хувь хэмжээг хязгаартай тогтоох, улмаар дотоодын ажиллах хүчнийг эдгээр салбарт түлхүү ажиллуулах нь зүйтэй байна. Харин барилга, эрчим хүч, боловсруулах үйлдвэрлэл зэрэг бүтээн байгуулалтын салбаруудад гадаад ажилтны тоо, хувь хэмжээг хязгаарлалтгүй тогтоож, ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг Засгийн газар тогтоож өгөх нь зүйтэй байна.

Иймд ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг эдийн засаг, бүтээн байгуулалтын бодлого, чиглэлийг харгалзан Засгийн газар тогтоохоор шинэ хэсэг нэмэхээр тусгасан.

2. Хуулийн төслийн 2 дугаар зүйлд: Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг "32.4.Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд ашигт малтмал, газрын тосны салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлж болно." гэж өөрчлөн найруулсан.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлд "32.7.Эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт, салбарын бодлого, дотоодын ажиллах хүчний хомсдол зэргийг харгалзан ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газар хөнгөлж, чөлөөлж болно." гэж нэмж тусгасан.

Дээрх хуулийн төслийн 32.7 дахь нэмсэн хэсэгт тусгагдаагүй Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд ашигт малтмал, газрын тосны салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлж болно.

байгууллагын гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлөхөөр өөрчлөн найруулж тусгасан зохицуулалт юм.

3. Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын, 23 дугаар зүйлийн 23.5.6 дахь заалтын "тодорхойлолт" гэснийг "цахим лавлагаа" гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн "10 дугаар" гэснийг "12 дугаар" гэж, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийн дугаарыг "32.8" гэж, 32.8 дахь хэсгийн дугаарыг "32.9" гэж, 32.9 дэх хэсгийн дугаарыг "32.10" гэж тус тус өөрчлөхөөр тусгасан.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-д "нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх." гэж заасны дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар хуулийн этгээдээс бичгээр шаарддаг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт болон нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолтыг мэдээлэл хариуцагч төрийн байгууллага хооронд цахимаар солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор цаасан лавлагааг "цахим лавлагаа" болгон өөрчлөлт оруулсан.

Гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох асуудал нь цаг хугацааны хувьд төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсны дараа шийдвэрлэх нь илүү зохимжтой байгаа тул уг тоо, хувь хэмжээг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах өөрчлөлт оруулахаар тусгасан.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд "Эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт, салбарын бодлого, дотоодын ажиллах хүчний хомсдол зэргийг харгалзан ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрийг Засгийн газар хөнгөлж, чөлөөлж болно." гэсэн зохицуулалтыг дээрх хуулийн 32 дугаар зүйлд 32.7 гэсэн хэсэг болгон шинээр оруулахаар тусгасан.

Энэхүү зохицуулалтыг тусгасантай холбоотойгоор Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32.7, 32.8, 32.9 гэсэн хэсгийн дугаарыг 32.8, 32.9, 32.10 гэж өөрчлөх зохицуулалтыг оруулсан болно.

4. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсгийн "Цахим системээр зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх, цахим системийг ашиглах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэснийг, 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалтын "23.4, 23.5.4" гэснийг хасахаар тус тус тусгасан.

Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 01 дугаар сарын 02-ны өдрөөс мөрдөж эхэлсэн.

Тус хуулийн 8.1 дүгээр зүйлийн 10.1 дэх хэсэгт "Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрлийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 8.2 дугаар зүйлийн 9.1 дэх хэсэгт "гадаад ажилтныг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэхээр урих", 9.2-д "гадаад ажилтан Монгол Улсад хөдөлмөр эрхлэх" энгийн зөвшөөрлийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно гэж заасан.

Мөн хуулийн 7.1.1-д "Энэ хуульд заасан зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан

түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид "зөвшөөрлийн нэгдсэн сан" гэх/-тай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна.", 7.1.5-д "Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална." гэж тус тус заасан.

Энэ хүрээнд Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 251 дүгээр тогтоолоор "Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх" журам батлагдсан.

Тус журмаар зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой явцын мэдээллийг зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тогтмол мэдээлэх, эрх бүртгэж байршуулах, сангаас иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Иймд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсгийн "Цахим системээр зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх, цахим системийг ашиглах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэснийг хасахаар оруулсан болно.

5. Хуулийн төслийн 5 дугаар зүйлд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 23.5.4 дэх заалт, 23.9 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.5, 32.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болгохоор тусгасан.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23.4-т "Ажил олгогч хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн санд ажлын байрны зарыг байршуулж, ажилтныг идэвхтэй хайж эхэлснээс хойш ажлын 14 өдрийн дотор дотоодоос ажилтан авч чадаагүй бол гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэх урилга хүсэх эрхтэй." гэж заасан. Хуульд заасан дээрх хугацаа нь улирлын чанартай бүтээн байгуулалтын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад гадаад ажилтан урих үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд хүндрэл учруулдаг асуудлыг шийдвэрлэхээр тухайн зохицуулалтыг хүчингүй болгохоор оруулсан.

Дээрх зохицуулалтыг дагаж хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.4 дэх заалт, 23.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болгохоор тусгасан.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлд "32.7.Эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт, салбарын бодлого, дотоодын ажиллах хүчний хомсдол зэргийг харгалзан ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газар хөнгөлж, чөлөөлж болно." гэсэн зохицуулалтыг нэмж оруулахаар тусгасан.

Тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.5-д аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газраас бусад төрийн өмчит хуулийн этгээдийн гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газрын шийдвэрээр хөнгөлж, чөлөөлөхөөр, 32.6-д Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан тохиолдолд ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөхөөр тус тус заасан нь хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгасан 32.7 дахь хэсгийн зохицуулалтад багтаж байгаа тул тус хуулийн 32.5, 32.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болгохоор оруулсан.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 32.7 дахь хэсэг нэмсүгэй:

“32.7.Эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт, салбарын бодлого, дотоодын ажиллах хүчний хомсдол зэргийг харгалзан ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газар хөнгөлж, чөлөөлж болно.”

2 дугаар зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“32.4.Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд ашигт малтмал, газрын тосны салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлж болно.”

3 дугаар зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын, 23 дугаар зүйлийн 23.5.6 дахь заалтын “тодорхойлолт” гэснийг “цахим лавлагаа” гэж, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “10 дугаар” гэснийг “12 дугаар” гэж, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийн дугаарыг “32.8” гэж, 32.8 дахь хэсгийн дугаарыг “32.9” гэж, 32.9 дэх хэсгийн дугаарыг “32.10” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.10 дахь хэсгийн “Цахим системээр зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх, цахим системийг ашиглах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэснийг, 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалтын “23.4, 23.5.4” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 23.5.4 дэх заалт, 23.9 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.5, 32.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АХШХТХ	Ажиллах хүний шилжилт хөдөлгөөний тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХЭДтХ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг үнэлэхээр хуулийн төслөөс сонгосон зүйл, хэсэг.....	3
Хүснэгт 2. Сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгсэл.....	4
Хүснэгт 3. Зорилгод хүрэх байдал буюу хуулийн төсөлд тусгагдсан байдал	4
Хүснэгт 4. Хувийн хэвшилд тулгардаг голлох хүндрэл бэрхшээл, тэдгээрийг даван туулахад чиглэгдсэн зохицуулалт	6
Хүснэгт 5. Хэрэгжүүлэх субъект, уг субъектэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ байгаа эсэх.....	6
Хүснэгт 6. Хуулийн төслийн агуулгад тавих нийтлэг шаардлагын хүрээнд хийсэн үнэлгээ..	7
Хүснэгт 7. Хуулийн төслийн харилцан уялдаатай байдлын үнэлгээ	9

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Үнэлгээ хийх хуулийн төсөл нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулагдсан болно.

Үнэлгээний тайланг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал" /Цаашид "Аргачлал" гэх/-ын дагуу боловсруулж бэлтгэв.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлыг Аргачлалын дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Үнэлгээг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, зорилт, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, Аргачлалд дурдсан нийт 6 шалгуур үзүүлэлтээс дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
4. Ойлгомжтой байдал;
5. Харилцан уялдаа.

"Зорилгод хүрэх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан асуудал, хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоохын тулд сонгосон болно.

"Практикт хэрэгжих боломж" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх

субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлэхээр сонгов.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийг ашиглан хуулийн төслөөр үүрэг хүлээлгэсэн, шинэ бүтэц, чиг үүрэг нэмсэн зохицуулалтад шууд хамаарах этгээд уг зохицуулалтыг хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгаж үр нөлөөний үнэлгээг хийнэ.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдэд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгаж хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийж тусгай тайлан гаргасан тул “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

3.1. Шалгуур үзүүлэлт: “Зорилгод хүрэх байдал”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд харьцуулах аргаар дүн шинжилгээ хийнэ.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалаас харвал хуулийн төсөл боловсруулах эрх зүйн үндэслэл нь доор дурдсанаар тодорхойлогдож байна. Үүнд:

- Ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг эдийн засаг, бүтээн байгуулалтын бодлого, чиглэлийг харгалзан Засгийн газар тогтоох;

- Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд ашигт малтмал, газрын тосны салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлөхийг Засгийн газар тогтоох;

- Гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох асуудал нь цаг хугацааны хувьд төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсны дараа шийдвэрлэх нь илүү зохимжтой байгаа тул уг тоо, хувь хэмжээг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах;

- Аж ахуйн нэгж, байгууллагууд гадаад улсаас ажилтан авч ажиллуулах урьдчилсан зөвшөөрлийн хүсэлт гаргахад тухайн ажлын байрыг нийтэд ажлын 14 өдөр зарласан байх зохицуулалт нь хүндрэлтэй байгаа тул дээрх хугацааг хүчингүй болгох;

- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 23.10 дахь хэсгийн “Цахим системээр зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх, цахим системийг ашиглах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэснийг хүчингүй болгох.

Хуулийн төсөл батлагдсанаар дээр дурдсан зорилтууд хэрэгжих хангалттай орчин бүрдэх эсэхэд дүн шинжилгээ хийхийн тулд хуулийн төслөөс холбогдох зүйл, заалтуудыг сонгон авч үр нөлөөг нь үнэлэв. Үүнд:

Хүснэгт 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үр нөлөөг үнэлэхээр хуулийн төслөөс сонгосон зүйл, хэсэг

№	Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилт	Сонгосон зүйл, хэсэг
1	ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг эдийн засаг, бүтээн байгуулалтын бодлого, чиглэлийг харгалзан Засгийн газар тогтоох	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг (32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, 32.8 дахь)
2	гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтоох	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг)
3	гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох асуудал нь цаг хугацааны хувьд төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсны дараа шийдвэрлэх нь илүү зохимжтой байгаа тул уг тоо, хувь хэмжээг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах;	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг (22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг)

3.2. Шалгуур үзүүлэлт: “Практикт хэрэгжих боломж”

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган, бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэгч субъектүүдэд ачаалал, бэрхшээл учруулах эсэх, учирч болох эрсдэлийг бууруулах арга зам байгаа эсэхийг тодруулав.

3.3. Шалгуур үзүүлэлт: “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг сонгон авч дүн шинжилгээ хийнэ. Ингэхдээ дараах асуултад хариулахыг эрмэлзсэн. Үүнд:

1. Хуулийн төслийг хэрэгжүүлэх боломж хэр байгаа;
2. Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх;
3. Хэрэгжүүлэх субъект байгаа бол түүнд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ бий эсэх зэрэг асуудлын хүрээнд үр нөлөөг үнэлсэн болно.

3.4. Шалгуур үзүүлэлтүүд: “Ойлгомжтой байдал”, “Харилцан уялдаа”

“Ойлгомжтой байдал”, “Харилцан уялдаа” гэсэн 2 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо /Хуулийн төсөл 2 зүйлтэй/.

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Үнэлгээний өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулъя. Үүнд:

Хүснэгт 2. Сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгсэл

№	Сонгосон шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	“Зорилгод хүрэх байдал”	Хуулийн төсөл бүхэлдээ	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	“Практикт хэрэгжих боломж”	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль хэрэгжих боломжид дүн шинжилгээ хийх
3	“Хүлээн зөвшөөрөгдөх байдал”	Хуулийн төсөл бүхэлдээ	Хувийн хэвшилд тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, тэдгээрийг даван туулахад чиглэгдсэн зохицуулалтыг харьцуулж үнэлэх
4	“Ойлгомжтой байдал”	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах
5	“Харилцан уялдаа”	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээр дурдсан шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангах эрх зүйн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг авч үзье.

Хүснэгт 3. Зорилгод хүрэх байдал буюу хуулийн төсөлд тусгагдсан байдал

№	Үзэл баримтлалд тусгагдсан зорилт	Зорилгод хүрэх байдал буюу хуулийн төсөлд тусгагдсан байдал
---	-----------------------------------	---

1	ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг эдийн засаг, бүтээн байгуулалтын бодлого, чиглэлийг харгалзан Засгийн газар тогтоох	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсэн нь зорилгод нийцэж байна. Үүнд: “32.7.Эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт, салбарын бодлого, дотоодын ажиллах хүчний хомсдол зэргийг харгалзан ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газар хөнгөлж, чөлөөлж болно.” Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсэн нь зорилгод нийцэж байна. Үүнд: Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8 дахь хэсгийн “ажлын байрны” гэсний дараа “төлбөрийн хэмжээг тогтоох,”
2	гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтоох	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсан нь зорилгод нийцэж байна. Үүнд: “32.1.Хуульд өөрөөр заагаагүй бол гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтооно. Ажлын байрны төлбөрийн нэг сарын хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс ихгүй байна.”
3	гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох асуудал нь цаг хугацааны хувьд төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсны дараа шийдвэрлэх нь илүү зохимжтой байгаа тул уг тоо, хувь хэмжээг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах;	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд доор дурдсан агуулгаар өөрчилсөн нь зорилгод нийцэж байна. Үүнд: Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “10 дугаар” гэснийг “12 дугаар” гэж, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийн дугаарыг “32.8” гэж, 32.8 дахь хэсгийн дугаарыг “32.9” гэж, 32.9 дэх хэсгийн дугаарыг “32.10” гэж,

4.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчид, ажил олгогчдын төлөөлөлтэй санал солилцсон болно. Түүнчлэн холбогдох байгууллагын статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийн

шалгасан. Хуулийн төсөл нь нэг талаас, Монгол Улсад мөрдөгдөж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих талаарх бодлого, хууль тогтоожид бүрэн нийцсэн, нөгөө талаас, аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөх нь хувийн хэвшилд ирэх ачааллыг бууруулах, хөрөнгө оруулагчдыг дэмжих, эдийн засгийг сэргээх практик ач холбогдолтой байхаар байна.

4.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

1. Төслийг хэрэгжүүлэх боломж хэр байгааг үнэлсэн байдал:

Энэхүү хуулийн хэрэгжилтэд хувийн хэвшилд тулгардаг голлох хүндрэл бэрхшээл, тэдгээрийг даван туулахад чиглэгдсэн зохицуулалтыг дараах хүснэгтэд харьцуулж үнэлэв.

Хүснэгт 4. Хувийн хэвшилд тулгардаг голлох хүндрэл бэрхшээл, тэдгээрийг даван туулахад чиглэгдсэн зохицуулалт

№	Голлох хүндрэл, бэрхшээл	Хэрэгжүүлэх боломж
1	Дотоодоос хангах боломжгүй, хомсдолтой байгаа ажлын байранд гадаад ажилтан авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт, салбарын бодлого, дотоодын ажиллах хүчний хомсдол зэргийг харгалзан ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газар хөнгөлж, чөлөөлөх боломж бүрджээ.
2	Гадаад ажилтны ажлын байрны 1 сарын төлбөрийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр төлж байгаа нь ажил олгогч, аж ахуйн нэгж, байгууллагад хүндрэлтэй.	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтоох боломж бүрдэнэ. Мөн ажлын байрны төлбөрийн нэг сарын хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс ихгүй байхаар зохицуулсан.

2. Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх болон уг субъектэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ байгаа эсэхийг үнэлсэн байдал:

Хүснэгт 5. Хэрэгжүүлэх субъект, уг субъектэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ байгаа эсэх

№	Субъект	Гүйцэтгэх үүрэг	Боломж, бололцоо /санхүү, хүний нөөц зэрэг/ байгаа эсэх
---	---------	-----------------	---

1	Засгийн газар	Эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт, салбарын бодлого, дотоодын ажиллах хүчний хомсдол зэргийг харгалзан ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлж, чөлөөлөх	Санхүү, хүний нөөц зэрэг боломж, бололцоо байгаа
2	Засгийн газар	Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтоох боломж бүрдэнэ. Мөн ажлын байрны төлбөрийн нэг сарын хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс ихгүй байхаар зохицуулах	Санхүү, хүний нөөц зэрэг боломж, бололцоо байгаа

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд дурдсан үүргийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудад нэмэлтээр зардал шаардагдахгүй бөгөөд батлагдсан орон тоо, төсвөөр ажиллахаар тооцсон байна.

4.4. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгав. Ингэхдээ хуулийн холбогдох заалтад дурдсан шаардлагыг хангасан эсэхэд үнэлгээ өгсөн. Үнэлгээний дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6. Хуулийн төслийн агуулгад тавих нийтлэг шаардлагын хүрээнд хийсэн үнэлгээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг хуулийн төслийн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн байна.
29.1.2.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Хувийн хэвшилд ирэх ачааллыг бууруулах, хөрөнгө оруулагчдыг дэмжих, эдийн засгийг сэргээх, хөдөлмөр эрхлэлтийн салбарт төр-

	хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих асуудлыг тусгасан байна.
29.1.3.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5. Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.6.Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.
29.1.8.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.Шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлага хангасан.
29.1.10.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэхгүй.

29.1.11.Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Хуулийн төсөл нь нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулагдсан тул "зорилго" гэсэн тусгай зүйл тусгах шаардлага байхгүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.Хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.5.Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан.

4.5. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан "Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах" хэрэгслийн хүрээнд дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог үнэлэв.

Хүснэгт 7. Хуулийн төслийн харилцан уялдаатай байдлын үнэлгээ

№	Асуулт	Үнэлгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм
2	Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм
5	Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм

7	Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага, ажил олгогчдын холбоо, ТББ-аар гүйцэтгүүлэх боломжтой
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Үгүй
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Тийм
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй
13	Хуулийн төслийн зүйл, заалт нь жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тийм
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Үгүй

ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1. Шалгах хэрэгслийг хэрэглэсэн үр дүнг баримтжуулах

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтран баталсан үзэл баримтлалын хүрээнд боловсруулсан хуулийн төслийн хувилбарт энэхүү үр нөлөө үнэлэх судалгааны ажлыг хийлээ. Хуулийн төсөлд дүн шинжилгээ хийж, зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуультай хэрхэн уялдсан, хуулийн төсөл батлагдсанаар бий болох эдийн засгийн үр дагавар, зардал тооцоо зэргийг судлахдаа холбогдох хуулиудаас гадна ашигласан эх сурвалжид дурдсан материалыг ашигласан болно.

5.2. Үр дүнг үнэлэх нь

Шалгах хэрэгслийг хэрэглэсэн үр дүнг баримтжуулах шатанд цуглуулсан мэдээ, мэдээлэлд тулгуурлан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үед гарсан үр дүнг энэ хэсэгт нэгтгэж бичив.

1. *“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээний үр дүн*

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан 2 үндсэн зорилтыг хангах эрх зүйн зохицуулалтыг хуулийн төсөлд бүрэн тусгасан байна.

2. *“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээний үр дүн*

Хуулийг хэрэгжүүлэх байгууллагууд болох Засгийн газар, Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд энэ хуулийн хэрэгжилтийг хангах боломжтой.

3. *“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээний үр дүн*

Хувийн хэвшилд тулгараад байгаа гол бэрхшээлийг арилгах зорилгоор хуулийн төсөл боловсруулагдсан тул хүлээн зөвшөөрөгдөж, хэрэгжих бүрэн боломжтой байна.

4. *“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээний үр дүн*

Хэрэглэх, хэрэгжүүлэх байгууллагууд хуулийн төслийг зөв зүйтэй гэж үзсэн байна.

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлийн дагуу үнэлж үзэхэд Монгол Улсын Үндсэн Хууль, бусад хууль, ОУХБ-ын “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай” 122 дугаар конвенци, “Хөдөлмөрийн эрхлэлтийн хувийн

байгууллагын тухай" 181 дүгээр конвенци зэрэг олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй тус тус нийцсэн нь хуулийн төсөл ойлгомжтой болсныг тодотгож байна гэж үзлээ.

5. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээний дүн

Хуулийн төслийн дотоод уялдаа хангагдсан байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсээгүй байна.

5.3. Үнэлгээг үндэслэн гаргасан зөвлөмж

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дотоодоос хангах боломжгүй, хомсдолтой байгаа ажлын байранд гадаад ажилтан авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх ингэснээр, бизнес эрхлэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, хөгжлийн төслийг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулсан байна. Хуулийн төслийг "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу үнэлэхэд үзэл баримтлал болон хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байна.

---oOo---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, хуулийн төсөл

- Монгол Улсын Үндсэн хууль, legalinfo.mn
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын "Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай" 122 дугаар конвенци, түүнийг дагалдаж гарсан "Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай" 122 дугаар зөвлөмж, Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга замын талаарх санал, "Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай (Нэмэлт зүйлүүд)" 169 дүгээр зөвлөмж;
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын "Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай" 181 дүгээр конвенци, "Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай" 188 дугаар зөвлөмж;
- "Хөдөлмөрийн ирээдүйн тухай" ОУХБ-ын Зууны тунхаг, https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_724946.pdf
- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа – 2050" баримт бичиг
- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"
- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"
- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал
- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

---000---



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАХ СУДАЛГАА

ГАРЧИГ

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ.....	1
1.1. Тулгамдаж буй асуудал, түүний цар хүрээ	1
1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд.....	3
1.3. Тулгамдсан асуудлын учир шалтгаан	4
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО.....	4
2.1. Зорилго, зорилт.....	4
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРЬЦУУЛАЛТ	5
3.1. Асуудлыг зохицуулах хувилбарууд.....	5
3.2. Зорилгод хүрэх байдал.....	5
3.3. Зардал, үр өгөөжийн харьцаа, үр дүнгийн харьцуулалт	5
3.4. Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай	5
3.4.1. Зохицуулалтын талаарх гадаадын улс орнуудын туршлага	6
3.4.2. Хамгийн үр дүнтэй хувилбар	5
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨ	8
4.1. Хүний эрх, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө.....	8
4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө.....	8
4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	9
4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө	9
4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	8
4.2. Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар	9
ТАВ. ДҮГНЭЛТ.....	9
ХАВСРАЛТ.....	10

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”¹-ын /цаашид “Аргачлал” гэх/ дагуу тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

1.1. Тулгамдаж буй асуудал, түүний цар хүрээ

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5-д “Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөх” гэж заасан.

УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ мөрдөгдөж эхлэхээс өмнө батлагдсан тул ажлын байрны төлбөрийг 50 хувь хөнгөлөх зохицуулалтыг хуульд тусгах зайлшгүй шаардлага үүсэж 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Мөн “Шинэ сэргэлтийн бодлого”-ийг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхойлохдоо Боомт, Эрчим хүч, Аж үйлдвэр, Хот, хөдөө, Ногоон хөгжил, Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлого, зорилтын хүрээнд туссан бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд дотоодоос хангах бололцоогүй байгаа ажиллах хүчийг гадаадаас авах боломжийг бүрдүүлсэн байхаар туссан.

Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг зарим салбарт чөлөөлөхтэй холбоотойгоор Засгийн газрын 2023 оны 45 дугаар тэмдэглэлээр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад даалгасан.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглалын судалгаагаар Монгол Улс 2028 он хүртэл хүн амын насны бүтцээс хамааран ажиллах хүчний хомсдолтой байх үр дүн гарсан.

Тус яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын “Хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийн барометрийн судалгаа”-гаар 2023 онд аж ахуйн нэгж, байгууллагуудын 26.3 хувь нь ажиллах хүчний хомсдолд орж, шаардлагатай ажилтанг авч ажиллуулж чадаагүй нь судлагдсан. Тус институтээс 2015-2023 оны хугацаанд жил бүр хийж гүйцэтгэсэн “Барометрийн судалгаа”-ны үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн дунд, урт хугацааны чиг хандлагыг таамаглан тооцсон.

Энэхүү таамаглалаар 2025 онд хөдөлмөрийн зах зээлд 1.319,0 мянган хүн ажил хөдөлмөр эрхлэх бөгөөд эдийн засгийн өсөлт 4.9 хувийн өсөлттэй байхын тулд 1.407,0 мянган ажиллагч, 7.2 хувийн өсөлттэй байхын тулд 1.420,0 мянган ажиллагч хэрэгцээтэй. Энэ нь 88.0-101.0 мянган ажиллагч хөдөлмөрийн зах зээлд нэмж нийлүүлэх шаардлагатай болохыг харуулж байгаа юм. Мөн уг үзүүлэлт нь 2028 онд 108.0-135.5 мянга, 2035 он гэхэд 159.0-228.0 мянга байхаар байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлэх Шинэ сэргэлтийн бодлого, улс орны хэмжээнд хэрэгжих томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд 2025 он хүртэл нийт 285.0 мянган ажлын байр бий болох урьдчилсан тооцоолол гарсанаас 140.0 гаруй мянга нь бүтээн байгуулалтын үед буюу ойрын хугацаанд бий болохоор байна.

Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн дагуу 2017 онд 11.1 мянга, 2018 онд 10.2 мянга, 2019 онд 10.3 мянган гадаад ажилтан хөдөлмөр эрхэлж байсан бол ковидын нөхцөл байдлаас шалтгаалан энэ тоо 2020-2021 онуудад буурч, 2020 онд 3.8 мянга, 2021 онд 5.3 мянга байсан бол эдийн засаг сэргэж, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа өргөжсөнөөр 2022 онд 10.8 мянга, 2023 онд 19.6 мянган гадаад ажилтан тус тус хөдөлмөр эрхэлсэн байна. Харин 2024 оны эхний 9 сарын байдлаар гадаадын 106 улсын 17831 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 5608 хүнээр буюу 45.8 хувиар нэмэгдсэн байна.

Дээрх нөхцөл байдалтай холбогдуулж хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний хомсдолыг нөхөх зорилгоор гадаадын иргэдийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэхэд уян хатан бодлого баримталж байна.

Тухайлбал гадаадын ажилтан авах бодлогод эдийн засгийн үйл ажиллагааны бүтээмж өндөртэй уул уурхай, олборлолт, мэдээлэл холбоо, санхүү даатгал, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбаруудад гадаад ажилтны тоо, хувь хэмжээг хязгаартай тогтоох, улмаар дотоодын ажиллах хүчнийг эдгээр салбарт түлхүү ажиллуулах нь зүйтэй байна. Харин барилга, эрчим хүч, боловсруулах үйлдвэрлэл зэрэг бүтээн байгуулалтын салбаруудад гадаад ажилтны тоо, хувь хэмжээг хязгаарлалтгүй тогтоож, ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг Засгийн газар тогтоож өгөх шаардлагатай байна.

Мөн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23.4-т "Ажил олгогч хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн санд ажлын байрны зарыг байршуулж, ажилтныг идэвхтэй хайж эхэлснээс хойш ажлын 14 өдрийн дотор дотоодоос ажилтан авч чадаагүй бол гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэх урилга хүсэх эрхтэй." гэж заасан. Хуульд заасан дээрх хугацаа нь улирлын чанартай бүтээн байгуулалтын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад гадаад ажилтан урих үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд хүндрэл учруулдаг асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

Түүнчлэн гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох хугацаа нь төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсоны дараа шийдвэрлэх нь илүү зохимжтой байна.

Мөн Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 01 дугаар сарын 02-ны өдрөөс мөрдөж эхэлсэн.

Тус хуулийн 8.1 дүгээр зүйлийн 10.1 дэх хэсэгт "Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрлийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 8.2 дугаар зүйлийн 9.1 дэх хэсэгт "гадаад ажилтныг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэхээр урих", 9.2-д "гадаад ажилтан Монгол Улсад хөдөлмөр эрхлэх" энгийн зөвшөөрлийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно гэж заасан.

Мөн хуулийн 7.1.1-д "Энэ хуульд заасан зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явц болон зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид "зөвшөөрлийн нэгдсэн сан" гэх/-тай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна.", 7.1.5-д "Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална." гэж тус тус заасан.

Үүний хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамнаас Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 251 дүгээр тогтоолоор "Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх" журмыг батлуулсан.

Тус журмаар зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой явцын мэдээллийг зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тогтмол мэдээлэх, эрх бүртгэж байршуулах, сангаас иргэн, хуулийн этгээдэд лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбоотой харилцааг зохицуулж байна.

Дээр дурдсан хууль эрх зүйн болон практик үндэслэл, шаардлагын дагуу Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.

1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1 Ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага	Ажил олгогч, хөрөнгө оруулагчийн төрд төлөх ажлын байрны төлбөрийн хэмжээг хөнгөлөх буюу чөлөөлснөөр бизнес эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх, бизнес эрхлэлтийг нэмэгдүүлэх зэрэг эерэг үр дүн бий болно.

1.3. Тулгамдсан асуудлын учир шалтгаан

Дотоодоос хангах боломжгүй, хомсдолтой байгаа ажлын байранд гадаад ажилтан авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, зарим тохиолдолд чөлөөлөх нь хувийн хэвшилд ирэх ачааллыг бууруулах, хөрөнгө оруулагчдыг дэмжих, эдийн засгийг сэргээх ач холбогдолтой юм. Мөн гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох асуудлыг цаг хугацааны хувьд улсын төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсоны дараа шийдвэрлэх нь илүү зохимжтой байна. Мөн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 23.4-т "Ажил олгогч хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн санд ажлын байрны зарыг байршуулж, ажилтныг идэвхтэй хайж эхэлснээс хойш ажлын 14 өдрийн дотор дотоодоос ажилтан авч чадаагүй бол гадаад ажилтныг хөдөлмөр эрхлүүлэх урилга хүсэх эрхтэй." гэж заасан. Хуульд заасан дээрх хугацаа нь улирлын чанартай бүтээн байгуулалтын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад гадаад ажилтан урих үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд хүндрэл учруулдаг асуудлыг хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөөр шийдвэрлэнэ.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

2.1. Зорилго, зорилт

Хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний хомсдолыг нөхөх зорилгоор гадаадын иргэдийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэхэд уян хатан бодлого баримтлах,

Эдийн засгийн үйл ажиллагааны бүтээмж өндөртэй уул уурхай, олборлолт, мэдээлэл холбоо, санхүү даатгал, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбаруудад гадаад ажилтны тоо, хувь хэмжээг хязгаартай тогтоох, улмаар дотоодын ажиллах хүчнийг эдгээр салбарт түлхүү ажиллуулах, ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг Засгийн газар тогтоодог байх үндсэн зорилготой. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараахь 3 зорилт дэвшүүллээ. Үүнд:

ЗОРИЛТ 1:

Ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг эдийн засаг, бүтээн байгуулалтын бодлого, чиглэлийг харгалзан Засгийн газар зохицуулах.

ЗОРИЛТ 2:

Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд ашигт малтмал, газрын тосны салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлөхийг Засгийн газар тогтоох;

ЗОРИЛТ 3:

Гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох асуудлыг цаг хугацааны хувьд төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсоны дараа шийдвэрлэх нь илүү зохимжтой тул уг тоо, хувь хэмжээг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах хууль зүйн үндэс бүрдүүлэх;

ЗОРИЛТ 4:

Аж ахуйн нэгж, байгууллагууд гадаад улсаас ажилтан авч ажиллуулах урьдчилсан зөвшөөрлийн хүсэлт гаргахад тухайн ажлын байрыг нийтэд ажлын 14 өдөр зарласан байх зохицуулалт нь хүндрэлтэй байгаа тул дээрх хугацааг хүчингүй болгох.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРЬЦУУЛАЛТ

3.1. Асуудлыг зохицуулах хувилбарууд

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар дээр дурдсан тулгамдаж буй асуудлуудыг бүрэн шийдвэрлэх зохицуулалт бий болгох боломжтой.

3.2. Зорилгод хүрэх байдал

	Зорилго	Хүрэх үр дүн
1.	Хуулиар зохицуулах шаардлагатай харилцааг тодорхой болгох.	✓ Ажлын байрны төлбөр төлөхөд хөнгөлөлт үзүүлэх, төлбөрөөс чөлөөлөх зохицуулалт оновчтой болно. ✓ Гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох асуудлыг цаг хугацааны хувьд төсвийн хөрөнгө оруулалтын нэр төрөл, хэмжээтэй уялдуулах боломж бүрдэнэ. ✓ Хөдөлмөр эрхлэх урьдчилан зөвшөөрөл авах процесс уян хатан болно.

3.3. Зардал, үр өгөөжийн харьцаа, үр дүнгийн харьцуулалт

Зардлын хувьд энэ хуулиар зохицуулсан гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох, ажлын байрны төлбөр төлөхөд хөнгөлөлт үзүүлэх, төлбөрөөс чөлөөлөх үйл ажиллагаа эрхлэх төрийн байгууллагад нэмэлтээр зардал үүсэхгүй.

Түүнчлэн гадаад ажилтан авч ажиллуулах аж ахуйн нэгж, байгууллагын төлөх ажлын байрны төлбөр буурах тул зарлага нь багасах боломжтой. Харин Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого тодорхой хэмжээнд буурах бөгөөд энэхүү буурах тооцооллыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны төсөвт тусгасан тул хүндрэл үүсэхгүй болно.

3.4. Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

3.4.1. Зохицуулалтын талаарх гадаадын улс орнуудын туршлага

Гадаад шилжилт хөдөлгөөн, тэр дундаа хөдөлмөрийн гадаад шилжилт хөдөлгөөнийг зохицуулах асуудал нь тухайн улс орон илгээгч орон уу, эсхүл хүлээн авагч орон уу гэдгээс ихээхэн хамаардаг. Манай улс илгээгч болон хүлээн авагч улсад хамаарагддаг.

Дэлхий нийтийн хандлагаас харахад, сүүлийн жилүүдэд гадаад шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдэж, 232 сая хүн гадаад шилжигч хэмээн бүртгэгдээд байна². Хөгжингүй орнуудын дийлэнх нь хүлээн авагч, харин хөгжиж буй орнууд, ялангуяа, Зүүн өмнөд Азийн орнууд илгээгч оронд ордог. Иймд хэрэв тухайн улс орон хүлээн авагч орон бол "immigration policy" буюу "шилжин ирэгчдэд зориулсан бодлого", харин илгээгч орон бол "emigration policy" буюу "шилжин явагчдад зориулсан бодлого"-ийн үзэл баримтлалтай, үүнийгээ хүн ам зүйн бодлого, эсхүл нийгмийн бодлогодоо шууд болон шууд бус хэлбэрээр тусгаж өгсөн байдаг.

Гадаадад ажиллах хүч илгээгч улсын хувьд Зүүн өмнөд Азийн улсууд хамгийн их хувь эзэлж байна. Тухайлбал, жил бүр ойролцоогоор 2 сая Ази ажилтан гадаад улсад ажиллахаар явдаг бөгөөд Филиппин, Индонези, Тайланд, Бирм, Вьетнам улсын иргэд даруй 60 хувийг эзэлдэг ажээ.³ Хүлээн авагч улсын хувьд, эхний аравт АНУ, ОХУ, ХБНГУ, Саудын Араб, Канад, ИБНВУ, Испани, Франц, Австрали, Энэтхэг улсууд ордог ч Азийн орнууд дотроо хамгийн их ажиллах хүлээн авагч оронд Сингапур, БНСУ орж байна. Барууны хөгжингүй орнуудын хувьд "Цагаачлалын хууль" хэрэгжүүлдэг бөгөөд шилжин ирэгчдийг хүлээн авах асуудлыг зохицуулах үндсэн арга хэрэгсэл нь "квотын систем" байдаг.

Хүлээн авагч орны төлөөлөл болгож БНСУ болон Сингапур улсын туршлагатай танилцаж, зарим хэрэгжүүлэх боломжтой хууль эрхзүй, бодлогын үзэл баримтлал, хэрэгжүүлэх арга замын талаар авч үзье.

БНСУ: Тус улс нь 51.5 сая хүн амтай, хүн амын өсөлтийн хувь 1.19 байгаа тул хүн амын насны бүтцэд өөрчлөлт орж, ажиллах хүчний тоо хэмжээ буурч, улмаар

² UNs, Department of Economic and Social Affairs, Population Division, September 2013, №2013/5

³ ОУХБ, Хөдөлмөрийн шилжих хөдөлгөөний бодлого ба менежмент: сургалтын модулиуд, 2004 он, 7 дахь тал

гаднаас ажиллах хүчин авах замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангаж, эдийн засгийн өсөлтөө дэмжих бодлого баримталж байна. БНСУ-ын Засгийн газраас 2004 оноос “Ажилчдын зөвшөөрлийн системийг тусгасан түр хугацаагаар ажиллах хүч авах” тухай хамтран ажиллах санамж бичгийг Азийн 15 улстай байгуулснаар ажиллах хүчин хүлээн авагч хөдөлмөрийн томоохон зах зээлийг бий болгожээ. Шалгаруулалт өрсөлдөөнтэй, хэлний шалгалт авна. Гэр бүлээр ажиллахыг дэмждэггүй. БНСУ-ын иргэнтэй гэр бүл болж, тухайн улс руу шилжин ирсэн хүний тоо 2000 оноос эрчимтэй өсч 2015 оны эцсээр 152,000 хүрсэн бөгөөд Монгол эмэгтэйчүүд эхний тавд ордог байна.⁴ Солонгосчуудын боловсролтой хэсэг нь гадагшаа, дийлэнх нь АНУ руу гардаг. Эх оронд нь заавал буцаан авчрахаасаа илүүтэй сурсан зүйлийг эх орондоо турших, нутагшуулах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаардаг байна. БНСУ нь 1990 оны НҮБ-ын Цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенцид элсээгүй. 2010 оны шинэчлэн найруулсан Гадаадын ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулиар энэхүү харилцааг зохицуулдаг. Сонгон шалгаруулах, зөвшөөрөл олгох хугацаа, хөдөлмөрийн гэрээ, даатгал – баталгаа, дэмжлэг, ажлын байр өөрчлөх, шийтгэл зэрэг олон асуудлыг тусгажээ. БНСУ хөдөлмөр эрхлэгч гадаад иргэдийн тоо тухайн орны нийт хөдөлмөр эрхлэгчдийн 30-аас илүү хувьд хүрвэл тухайн орны Засгийн газарт сануулга өгч, ажилтан шинээр авахыг зогсоодог байна.

Сингапур улс: Нийт 3.4 сая хүн амтай. Гадаад ажилтныг өндөр мэргэшил, ур чадвар бүхий болон ердийн ажилтан хэмээн ангилдаг. Ажил эрхлэх зөвшөөрөл олгохдоо сарын 8,000 хүртэл ам.долларын цалинтай, 4,500-7,999 хүртэл ам.доллар цалинтай, 4,500 ам.доллар хүртэл цалинтай ажил хэмээн ялгаж, визний ангиллыг олгодог. Эрүүл мэндийн үзлэг зайлшгүй хийж, ХДХВ, сүрьеэгийн үзлэгт оруулдаг. Гадаад ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн хууль, Хөдөлмөр зуучлалын хууль, Ажилтны татварын тухай хууль, Цагаачлалын хууль, Гадаад ажилчдын төлбөр болон ажил эрхлэх зөвшөөрлийн тухай хууль зэргээр зохицуулдаг. Хүний нөөцийн яамтай. Боловсролын түвшнээс хамааран, тухайлбал, өндөр мэргэшил, дунд зэргийн мэргэжил, бага боловсрол, ур чадвартай хэмээн ялгаж, ажил эрхлэх зөвшөөрөл олгоно.⁵ Сингапур улсын нэг онцлог нь гадаадын ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж буй ажил олгогчоос татвар авдаг. Өөрөөр хэлбэл, барилгын ажилтанд сарын 700 долларын цалин олгох бөгөөд 450 долларын татвар төлнө. Энэхүү татвар нь өндөр мэргэшил, ур чадвартай ажилтанд бага ногдохоор харин үйлдвэр, барилгын, үйлчилгээний ажилтанд өндөр ногдохоор хуульчилсан. Энэ нь дотоодын хөдөлмөрийн зах зээлээ хамгаалах, хяналттай байлгах бодлогын нэг хэлбэр юм⁶. Энэ татвар нь жилдээ 2.5 тэрбум доллар болдог байна.

⁴ Гадаад шилжих хөдөлгөөний тоон ба чанарын судалгаа (Хүний хөгжил судалгаа, сургалтын төв, 2017 он), 120 дахь тал

⁵ <http://dirp3.pids.gov.ph/webportal/CDN/PUBLICATIONS/pidspjd11-singapore.pdf>

⁶ <http://reflectivedisequilibrium.blogspot.com/2014/05/migration-levies-and-unskilled-labor.html>

Товч дүгнэхэд, хүлээн авагч улсын хувьд, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд нийлүүлэлт бага ажлын байранд гадаадын ажиллах хүчнийг ажиллуулах, бүртгэл, хяналтын тогтолцоог иж бүрнээр нь хэрэгжүүлдэг.

3.4.2. Хамгийн үр дүнтэй хувилбар

Хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах хувилбар нь *"хамгийн үр дүнтэй хувилбар"* гэж үзэж байна.

Хуулийн төслийн бүтэц, агуулга

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараах бүтэцтэйгээр боловсруулна. Үүнд:

Нэгдүгээр зүйл. Ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт, салбарын бодлого, дотоодын ажиллах хүчний хомсдлыг харгалзан Засгийн газар зохицуулахаар нэмсүгэй.

Хоёрдугаар зүйл. Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд ашигт малтмал, газрын тосны салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөхийг Засгийн газар тогтоож байхаар өөрчилсүгэй.

Гуравдугаар зүйл. Гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох асуудлыг цаг хугацааны хувьд төсөв батлагдсаны дараа буюу ирэх оны төсвийн хөрөнгө оруулалт тодорхой болсоны дараа шийвэрлэх нь илүү зохимжтой тул уг тоо, хувь хэмжээг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор баталдаг болгон өөрчилсүгэй.

Дөрөвдүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагууд гадаад улсаас ажилтан авч ажиллуулах урьдчилсан зөвшөөрлийн хүсэлт гаргахад тухайн ажлын байрыг нийтэд ажлын 14 өдөр зарласан байх зохицуулалт нь хүндрэлтэй байгаа тул дээрх хугацааг хүчингүй болгох;

- Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 23.10 дахь хэсгийн "Цахим системээр зөвшөөрлийн үйлчилгээ үзүүлэх, цахим системийг ашиглах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэснийг хүчингүй болгох.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨ

4.1. Хүний эрх, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Эерэг нөлөөтэй.

4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Дотоодоос хангах боломжгүй, хомсдолтой байгаа ажлын байранд гадаад ажилтан авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх нь хувийн хэвшилд ирэх ачааллыг бууруулах, хөрөнгө оруулагчдыг дэмжих эерэг үр нөлөө үзүүлнэ.

4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хөдөлмөрийн үндэсний зах зээлийг хамгаалах, мэргэжилтэй, ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлэх, дэлхийн улс орнуудын соёл, зан заншлаас суралцах, Монгол Улсад нэвтрүүлэх зэрэг эерэг үр нөлөө гарна.

4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Аргачлалын 6.2-т заасан байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний суурь асуултаас үзэхэд энэхүү хуулийн төсөл нь байгаль орчинд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй байна.

(Хүний эрх, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний дэлгэрэнгүйг Хавсралтаас үзнэ үү)

4.2. Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлсэн болно.

ТАВ. ДҮГНЭЛТ

Гадаад ажилтны тоо, хувь хэмжээг хөрөнгө оруулалтын нэр төрөл, хэмжээтэй нягт уялдуулдаг болно.

Хуулийн төсөл батлагдсанаар гадаад ажилтан авч ажиллуулах ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, хөрөнгө оруулагчид төрд төлөх ажлын байрны төлбөрөөс хөнгөлүүлж, чөлөөлөгдөж, бизнес эрхлэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, хөгжлийн төслийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

---oOo---

ХАВСРАЛТ

Хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

4.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх тухай суурь конвенцид нийцүүлнэ.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Ашигт малтмал, газрын тосны салбарын аж ахуй нэгж, байгууллагаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдэд давуу байдал зарим талаараа бий болж магадгүй
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн	Тийм		

	оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх			
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Тийм	
2.Хүний эрхийг хязгаарласа н зохицуулалт	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх		Үгүй	

агуулсан эсэх	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)		Үгүй	
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Жендэрийн ялгавартайгаар оруулсан заалт байхгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш	Тийм		Хөдөлмөрийн гадаад шилжилт хөдөлгөөний зохицуулалтад

нийцүүлсэн эсэх	хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх			эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш боломж, тэгш эрхийг эдэлнэ.
-----------------	------------------------------------	--	--	--

4.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуудлууд	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм		
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	

	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Зардал буурна
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд		Үгүй	

	хязгаарлалт бий болгох эсэх			
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		Гадаад улсаас шинэ техник, технологи, шинэ ур чадвар нэвтрүүлэх.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм		
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	

	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Гадаадад мэргэжил, ур чадвар эзэмшсэн иргэд бизнес эрхлэх, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд эерэг нөлөөтэй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Ажлын байрны төлбөрөөс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрөх боломж багасна.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм		Засгийн газарт гадаад ажилтны төлбөрийн хэмжээг тогтоох, төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг зохицуулах үүрэг нэмэгдэнэ.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Улсын хөгжил, эдийн засагт хувь нэмэр оруулна
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

4.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
		Тийм	Үгүй	

1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм		
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс дагалдан суралцах үндсэн дээр мэргэшлийн түвшингээ ахиулах боломжтой.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Хөдөлмөрийн насны хүн ам.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм		Дотоодоос ханган нийлүүлэх боломжгүй ур чадвар шаардлагатай ажлын байранд гадны мэргэжилтнүүдийг авч ажиллуулснаар тухайн ажлын бүтээмж нэмэгдэх, улмаар гадны өндөр ур чадвартай мэргэжилтнүүдэд дотоодын ажиллах хүчийг дагалдуулан сургах боломж бүрдэнэ.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	

	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	

5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн		Үгүй	

	удирдлагад нөлөөлөх эсэх			
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	

4.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх		Үгүй	

2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН
ТООЦООНЫ ТАЙЛАН

ГАРЧИГ

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО	1
1.1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох	1
1.2. Зардлын тооцоо	1
1.3. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах.....	3
1.4. Үр дүн, санал	3
ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	4
2.1. Төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох	4
2.2. Ажил, үйлчилгээ гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох	4
2.3. Зардлын тооцоо	4
2.4. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах.....	7
ГУРАВ. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО	7
3.1. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох	7
3.2. Зардлын тооцоо	8
НЭГДСЭН ДҮГНЭЛТ	8
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	9

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

1.1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоохдоо хуулийн үйлчлэлд хамрагдах хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн зүйл, заалтыг үндэслэсэн.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 32.7-д "Эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт, салбарын бодлого, дотоодын ажиллах хүчний хомсдол зэргийг харгалзан ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газар хөнгөлж, чөлөөлж болно." гэж тусгасан.

Дээрх заалт нь иргэн, хуулийн этгээдэд зардал үүсгэхгүй харин хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үр дагавар үүсгэхээр байна.

1.2. Зардлын тооцоо

Хуулийн этгээдийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх зардлын тооцоо

"Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхдээ Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаанд Засгийн газар холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам"-д нэмэлт оруулж, уг журмын дагуу ашигт малтмал болон газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөлт үзүүлсэн. Журмын дагуу нийт 270 аж, ахуйн нэгж байгууллагын 4763 гадаад ажилтны 5.7 тэрбум төгрөгийн ажлын байрны төлбөрийг хөнгөлж, хувийн хэвшилд дэмжлэг үзүүлсэн.

УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ мөрдөгдөж эхлэхээс өмнө батлагдсан тул ажлын байрны төлбөрийг 50 хувь хөнгөлөх зохицуулалтыг хуульд тусгах зайлшгүй шаардлага үүсэж 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8-д "Гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөхтэй холбоотой журмыг Засгийн газар батална." гэж заасны дагуу журмын төслийг хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан боловсруулж, ЗГ-ын 2023 оны 99 дүгээр тогтоолоор батлуулсан.

Хууль журмын хүрээнд 2023 онд 406 аж ахуйн нэгж, байгууллагын 5551 гадаад ажилтанд 13.0 тэрбум төгрөгний ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт үзүүлээд байна.

Мөн 2022 онд нийт 10850 гадаад ажилтанд зөвшөөрөл өгч Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлснээс Засгийн газрын 2021 оны 392. 2022 оны 292 дугаар

тэрбум төгрөгний ажлын байрны төлбөрөөс 100 хувь чөлөөлсөн. Мөн хуульд заасны дагуу уг хуулийн 21.2.1, 21.2.3, 21.3.1, 22.5-д заасан гадаад ажилтан болон боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, спортын байгууллагад гэрээгээр ажиллах эмч, эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжлийн багш, дасгалжуулагчийг төлбөрөөс чөлөөлөх хүрээнд нийт 287 аж ахуйн нэгж, байгууллагын 1479 гадаад ажилтныг **11.7 тэрбум** төгрөгний ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн.

2023 онд 259 аж ахуйн нэгж, байгууллагын 5915 гадаад ажилтныг **7.1 тэрбум** төгрөгний ажлын байрны төлбөрөөс чөлөөлөөд байна.

Эдгээр хөнгөлөлт, чөлөөлөлтийн үйл ажиллагааны дагуу аж ахуйн нэгж, байгууллагууд **2022 онд нийт 30.2 тэрбум, 2023 онд 28.2 тэрбум** төгрөгийг төлөхгүйгээр эдийн засгийн дэмжлэг авсан болно.

2025 онд эдийн засгийн үйл ажиллагаа сэргэж, бүтээн байгуулалтууд эрчимжиж гадаад ажилчдын тоо дээрх үзүүлэлтээс буурахгүй гэж тооцож байгаа тул аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны төлбөрт төлөх зардлын хэмжээг 28.2 тэрбум төгрөгөөс багагүй хэмжээгээр чөлөөлж хувийн хэвшлийн зардлыг бууруулна гэж үзэж байна.

Тоон үзүүлэлтийн тооцоо

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүргийг хичнээн аж ахуйн нэгж, байгууллагад, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлын тоог давтамжийн тоогоор үржүүлнэ. Үүнд:

1. Тухайн үүргийг хүлээх аж ахуйн нэгж, байгууллагын тоо (Тохиолдлын тоо);
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо).

Тохиолдлын тоо: Жилд дунджаар 500 аж ахуйн нэгж, байгууллага хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдана.

Давтамжийн тоо: Хуулийн этгээд жилд 1 удаа хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдэлнэ.

Хуулийн этгээдийн хөнгөлөлт эдлэх зардлын тооцоо

Нийт хөнгөлж, чөлөөлөгдөх зардлын хэмжээ нь 30 орчим тэрбум төгрөг байхаар урьдчилсан тооцоо гарч байна.

Нэмэлт зардлын тооцоо

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийн улмаас хуулийн этгээдэд үүсэх зардал, ачааллыг тооцоолох явцад гарч болох бусад зардлыг тооцоолов.

Аж ахуйн нэгж, байгууллага хуулийн төслийн 32.6-д заасан хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхтэй холбогдсон үйл ажиллагаа тус бүрээр зардлыг дараах хүснэгтэд тооцоолов.

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зардал, төгрөг	Тоон үзүүлэлт, байгууллагын тоо	Нийт зардал, төгрөг
Хөнгөлөлт эдлэхэд холбогдох зардал	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон эрх зүйн баримт бичиг бэлтгэх	Хэвлэлийн зардал	500	500	250,000
	Баталсан маягтын дагуу өргөдөл гаргах	Албан бичиг бичих	700	500	350,000
	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм	Хуулбар бэлтгэх	1580	500	790,000
	Асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас санал авах	Үйл ажиллагааны чиглэл, гадаад ажилтан авах мэдээлэл бэлтгэх	1500	500	750,000
Хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхтэй холбогдсон зардал					2,140,000

Хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхэд нэмэлт зардлын нийт дүн 2 сая 140 мянган төгрөг буюу нэг аж ахуйн нэгж, байгууллагад дунджаар 4280 төгрөг байна.

1.3. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт зардлыг нь тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, аж ахуйн нэгжид үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг дараах шалгуур ашиглан шалгалаа:

- ✓ Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх: Мэдээллийг 100% цахим хэлбэрээр хүргүүлэх, бичиг баримтын үнэн зөв байдлыг цахим хэлбэрээр шалгах боломжийг судлах шаардлагатай байна.
- ✓ Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх: Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийг эрчимжүүлэх зорилгоор нарийн мэргэжлийн гадаад ажилтны эрэлт, хэрэгцээ аж ахуйн нэгж, байгууллагад байх тул хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй.
- ✓ Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх: Хүсэлт гаргах аж ахуйн нэгж, байгууллага төсвийн жилдээ багтан хүсэлтээ гаргаснаар хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх эрх нь үүснэ.

1.4. Үр дүн, санал

Хуулийн төслийн хүрээнд нэг аж ахуйн нэгж, байгууллагад ногдох нэмэлт зардал 4 мянга 280 (4280) төгрөг байхаар урьдчилсан тооцоо гарч байна.

ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

2.1. Төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох

Хүснэгт 3. Үүрэг хүлээх байгууллагууд болон тэдгээрийн гүйцэтгэх үүрэг

Субъект	Гүйцэтгэх үүрэг
Засгийн газар	Эдийн засгийн өсөлт, бүтээн байгуулалт, салбарын бодлого, дотоодын ажиллах хүчний хомсдол зэргийг харгалзан ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газар хөнгөлж, чөлөөлнө.
Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөнгөлөлт, чөлөөлөлтийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх шийдвэрийн дагуу хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын урьдчилж төлсөн ажлын байрны төлбөрийн зөрүүг дараагийн төлбөрт шилжүүлэн тооцох, буцаан олгох арга хэмжээг авна.

2.2. Ажил, үйлчилгээ гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлөхөд гадаадаас ажиллах хүч авах асуудал хариуцсан яамны 1 ажилтан, холбогдох тушаал шийдвэрийг олон нийтэд нээлттэй байлгах мэдээлэл технологийн 1 ажилтан болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Ажиллах хүч авах хэлтсийн 4 ажилтан, буцаан олголт хариуцсан 1 ажилтан нийт 6 ажилтан ажил, үйлчилгээг гүйцэтгэж байна. Энэхүү нөхцөл байдлын улмаас тус асуудлыг хариуцсан байгууллагын орон тоог нэмэгдүүлэх шаардлага үүсэхгүй бөгөөд одоогийн хүний нөөцийн хүрээнд ажиллах боломжтой.

2.3. Зардлын тооцоо

Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагад үүсэх зардлыг урьдчилан тооцоолох үе шатанд:

- Хүний нөөцийн зардал /Төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал/
- Материаллаг зардал /Төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал/
- Бусад зардал /Тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал/-ыг тооцож гаргана.

2.3.1. Хүний нөөцийн зардал

Ажлын байрны төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх үйлчилгээг төрийн захиргааны 12 албан хаагч үндсэн чиг үүргийнхээ хүрээнд хийх учир хүний нөөцийн зардал үүсэхгүй болно.

2.3.2. Материаллаг зардал

Материаллаг зардалд тухайн үүргийг гүйцэтгэж буй нэг албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг ойлгоно. Тухайлбал, албан хаагчийн ажлын байр, өрөө тасалгаа, техник хэрэгсэл, шаардлагатай бусад зардлыг энд тооцох хэрэгтэй.

Хуульд нэмэлт орох үйлчилгээг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлдэг. Иймд дээрх зардлуудын дийлэнхийг, тухайлбал урсгал зардал /халаалт, цэвэр, бохир ус, цахилгаан, урсгал засвар гэх зэрэг/-ыг үйлчилгээний байр тус бүрээр ерөнхий байдлаар гаргадаг тул 1 ажилтанд зарцуулах материаллаг зардлыг нарийвчлан тооцож гаргах боломжгүй байна. Иймд "Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал"-д жишээ болгон авсан ХЗДХЯ-ны нэг ажилтны материаллаг зардлыг ашиглав.

Хүснэгт 4. Нэг албан хаагчид гарах материаллаг зардал

Зардлын нэр	Зардлын төрөл	Зардлын хэмжээ, төгрөг
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	124,000
	Ном, хэвлэл авах	54,745
	Шуудан холбоо	306,812
	Нийт	485,557
Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал	Түлш, халаалт	263,408
	Гэрэл, цахилгаан	128,239
	Цэвэр, бохир ус	599,438
	Урсгал засвар	127,752
	Газрын төлбөр	22,253
	Нийт	1,141,090
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж ¹	160,000
	Тавилга, эд хогшил ²	100,000
	Барилга, байгууламж ³	65,670
	Нийт	325,670

Дээр тооцсон бүх зардал нэг албан хаагчийн ажлын байрны дундаж материаллаг зардлыг бүрдүүлэх юм.

Хүснэгт 5. Ажлын байртай холбоотой үүсэх дундаж материаллаг зардал

¹ Нэг албан хаагчид хэрэглэгдэж буй техник, тоног төхөөрөмжийн үнийг дунджаар 800,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл хорогдлын хэмжээг Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан "Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцох журам, Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлыг тооцоход баримтлах хугацаа"-нд тусгаснаар 20% -иар тооцов.

² Тавилга, эд хогшлын үнийг дунджаар 1,000,000 төгрөгөөр тооцож, түүний элэгдэл, хорогдлыг Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгаснаар 10%-иар тооцов.

³ 2013 онд ХЗЯ-наас хийсэн "Хөдлөх эд хөрөнгийн болон түүнтэй холбоотой эрхийн барьцааны тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох судалгааны тайлан"-д дурдсан мэдээллийг ашиглав.

Материаллаг зардал	Зардлын хэмжээ, төгрөг
Урсгал зардал	485,557
Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал	1,141,090
Элэгдэл, хорогдлын зардал	325,670
Нийт	1,952,317

Үүнээс харахад нэг алба хаагчид гарах материаллаг зардлын хэмжээ дунджаар 1,952,317 төгрөг байна.

2.3.3. Бусад зардал

Бусад зардалд төрийн байгууллагаас тухайн ажил үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дагалдан гарах зардлыг авч үзнэ. Тухайлбал, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх, тусгайлсан програм хангамж хөгжүүлэх гэх зэрэг зардлыг дурдаж болгох юм.

Төрийн байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэхэд⁴ дунджаар 10.0 сая төгрөг зарцуулдаг.

Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгагдсан үүрэг буюу ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд дараах бусад зардал гарна гэсэн төсөөллөөр бусад зардлыг тооцлоо. Үүнд:

Хүснэгт 6. Бусад зардлын хэмжээ

Зардлын нэр	Зардлын хэмжээ, 1 жил/төгрөг
Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ	10,000,000
Нийт	10,000,000

2.3.4 Зардлыг нэгтгэн тооцох

Энэ үе шатанд төрд үүсэх нийт зардлыг тооцож гаргана. Ингэхдээ хүний нөөцийн зардал, материаллаг зардлын нийлбэрийг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлэн тооцох ба бусад зардлыг нэмж нийт зардлын хэмжээ гарах юм.

Хүснэгт 7. Нийт зардлын хэмжээ

Зардлын төрөл	Зардлын хэмжээ, төгрөг	Хүний нөөцийн хэрэгцээ	Нийт зардал, төгрөг
Хүний нөөцийн зардал	-	-	-
Материаллаг зардал	1,952,317	12	23,427,804
Бусад зардал	10,000,000	-	10,000,000

4 Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам", Хууль зүйн сайдын 2014 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан "Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний аргачлал", Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх

Нийт зардал	33,427,804
-------------	------------

Дээрх хүснэгтээс харахад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тусгасан ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад 33 сая 427 мянга 804 төгрөгийн зардал үүсэхээр байна.

Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах:

Хуулийн төсөлд шинээр нэмэгдэж байгаа буюу өөрчлөгдөж буй зохицуулалттай холбоотой төрд үүсэх зардлыг хэрхэн багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар боломж байгаа эсэхийг нягталж үзлээ.

Хувилбарыг нягтлах ажлыг дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гүйцэтгэв. Үүнд:

1. Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;
 2. Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх;
 3. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх;
- ✓ Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх: Мэдээллийг 100% цахим хэлбэрээр хүргүүлэх, бичиг баримтын үнэн зөв байдлыг цахим хэлбэрээр шалгах боломжийг судлах шаардлагатай байна.
 - ✓ Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх: Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийг эрчимжүүлэх зорилгоор нарийн мэргэжлийн гадаад ажилтны эрэлт, хэрэгцээ аж ахуйн нэгж, байгууллагад байх тул хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй.
 - ✓ Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх: Хүсэлт гаргах аж ахуйн нэгж, байгууллага төсвийн жилдээ багтан хүсэлтээ гаргасанаар хөнгөлөлт эдлэх эрх нь үүснэ.

2.4. Үр дүн, санал

Хүний нөөцийн хэрэгцээнээс үзэхэд гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг хариуцсан байгууллагын орон тоог нэмэгдүүлэх шаардлага үүсэхгүй бөгөөд одоогийн хүний нөөцийн хүрээнд ажиллах боломжтой.

ГУРАВ. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төслийн хүрээнд иргэнд нэмэлт зардал үүсгэх зохицуулалт ороогүй болно.

3.1. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт тодорхой шалгах асуултын дагуу зардлыг нь тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, иргэнд үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгалаа.

- ✓ Мэдээллийг 100% цахим хэлбэрээр хүргүүлэх, бичиг баримтын үнэн зөв байдлыг цахим хэлбэрээр шалгах боломжийг судлах шаардлагатай байна.

3.2. Үр дүн, санал

Иргэнд үүсэх зардлын хувьд нэмэлт ачаалал үүсэхээргүй байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Хуулийн этгээдийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх хэмжээ 30 орчим тэрбум төгрөг байхаар урьдчилсан тооцоо гарч байна.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төслийн хүрээнд нэг хуулийн этгээдэд үүсэх зардлын хэмжээ буюу нэмэлт зардал нь 4 мянга 280 төгрөг, төрийн байгууллагад ногдох зардал 33 сая 427 мянга 804 төгрөг байхаар урьдчилсан тооцоо гарч байна. Харин иргэн, хуулийн этгээдэд зардал үүсэхээргүй байна.

---000---